



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 25

Мөрөн сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Хөдөөгийн Шийдэл" ОНӨХХК-ийн хөрөнгийг түрээслэх, түрээслэн өмчлөх, төсөл сонгон шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжүүлж ажиллахыг "Хөдөөгийн шийдэл" ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Баттулга)-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

8712002034

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны
өдрийн ээлжит XVIII хуралдааны 25
дугаар тогтоолын хавсралт



“ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ОНӨХХК-ИЙН ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Шинэ хөдөө - Хөвсгөл” төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, Хөдөө аж ахуйн чадамжид суурилсан үйлдвэрлэл явуулах, хүний нөөцийг чадавхжуулах, малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх, эрчимжсэн аж ахуй, газар тариалангийн техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой байгуулагдсан “Хөдөөгийн шийдэл” ОНӨХХК (цаашид “Компани” гэх)-ийн хөрөнгийг удирдах, зөвлөн туслах, төсөл сонгон шалгаруулж иргэд, аж ахуйн нэгжид олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2 Төсөл сонгон шалгаруулах (цаашид “Журам” гэх) нь жижиг дунд үйлдвэр эрхлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуй нэгжид хугацаатай хөнгөлөлттэй (цаашид “зээл” гэх) олгох гэрээ байгуулах, хөрөнгө хүлээлгэн өгөх, талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3 Журмын дагуу төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн боловсруулсан холбогдох баримт бичгийн шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгж төсөлд хамрагдана.

1.4 Төсөлд хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуй нэгж (цаашид “Төсөл” гэх)-ийг сонгон шалгаруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх шийдвэр гаргахад туслах чиг үүрэг бүхий “Төсөл” сонгон шалгаруулах (цаашид “Ажлын хэсэг” гэх)-т аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газар болон бусад мэргэжлийн холбогдох байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэдийг ажлын хэсэгт томилон хамтран ажиллана. Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Зээлийн эх үүсвэр нөхцөл

2.1. Төслийн зээлийн эх үүсвэр нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөдөөгийн шийдэл” ОНӨХХК (цаашид “Компани” гэх)-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бүрдэнэ.

2.2. Зээлийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр тооцон үнэлж, хөрөнгийг олгоно.

Гурав. Зээл олгох хэлбэр

3.1. Зээлийг “Хөдөөгийн шийдэл” ОНӨХХК-аар дамжуулан олгоно.

3.2. Ажлын хэсгийн гаргасан шийдвэр, зөвлөн туслах саналыг үндэслэн компаниас гаргасан шалгуурыг хангасан иргэн, аж ахуй нэгжид хөрөнгийн зээлийг олгож, гэрээ байгуулна.

3.3. Зээлийн хөрөнгийг Монгол төгрөгөөр тооцож үнэлэх бөгөөд төгрөг, гадаад валютаар зээл олгохыг хориглоно.

Дөрөв. Төсөл сонгон шалгаруулах ажлын

хэсгийн бүрэлдэхүүний, эрх, үүрэг

4.1. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

4.1.1 Ажлын хэсгийн дарга, Нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн таваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.1.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь "Хөдөөгийн шийдэл" ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилсон дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

4.1.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл байж болно.

4.1.4. Ажлын хэсэг гишүүдийн дийлэнх, олонх ирснээр хурал хүчинтэйд тооцогдох ба хурлын явцыг дуу хураагуурт хуулах болон цаасан хэлбэрээр тэмдэглэл хөтөлж, дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.1.5. Ажлын хэсгийн гишүүн бүр нэг саналын эрхтэй оролцоно.

4.1.6. Ажлын хэсэг нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тоо, чанарт үнэлэлт өгч зөвлөн туслах болон төсөл сонгон шалгаруулах байдлаар оролцоно.

4.2. Ажлын хэсэг, түүний гишүүн дараах эрхтэй.

4.2.1 Төв батлах

4.2.2. Ажлын хэсэг нь төсөл хүлээн авахаас ажлын 14-өөс доошгүй хоногийн өмнө хуралдаж, төсөл хүлээн авах хугацааг тогтооно

4.2.3. Төсөл сонгон шалгаруулах хурлын товыг тогтооно

4.2.4 Төсөл сонгон шалгаруулах, холбогдох хууль журмын дагуу шийдвэр гаргахад зөвлөн туслах

4.2.5 Зээлийн хүсэлт ирүүлсэн иргэд, байгууллагаас шаардагдах баримт бичгийн бүрдлийн жагсаалтыг батлах

4.3. Ажлын хэсэг, түүний гишүүн дараах үүрэгтэй.

4.3.1 Ажлын хэсгийн гишүүд хурлын шийдвэр, зөвлөлдсөн асуудлын талаар бусдад задруулахгүй байх, бусдад давуу байдал бий болгохгүй байх

4.3.2 Ажлын хэсгийн гишүүн холбогдох хууль, журам зөрчихгүй байх

4.3.3 Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нар нь олонхын шийдвэрийг баталгаажуулан хурлын шийдвэрт гарын үсэг зурна.

4.4.4 Ажлын хэсгийн гишүүн нь зээл хүсэгч иргэн, аж ахуй нэгжтэй хамаарал бүхий ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээс сайн дураараа татгалзах үүрэгтэй.

Тав. Төсөлд тавигдах шаардлага

5.1. Хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлага

5.1.1 Төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдсэн байна.

5.1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

5.1.3. Төслийн товч танилцуулга

5.1.4 Иргэн, хуулийн этгээдийн нэр

5.1.5 Үйлдвэрлэл, үйлчилгээ худалдаа эрхэлж буй хаяг байршил.

5.1.6. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ түүнээс өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх 20-30%-аас доошгүй хөрөнгийн хэмжээ

5.1.7. Үйлдвэрлэл, үйлчилгээ болон худалдах бүтээгдэхүүний нэр төрөл

5.1.8. Одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл

5.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ худалдааны үйл ажиллагааны тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

5.2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний, худалдааны технологийн ажиллагаа

5.2.2. Түүхий эдийн чанарын үзүүлэлт нөөц

5.2.3. Үйлдвэрлэлийн хүчин чадал

5.2.4. Хэрэгжүүлэх төслийн тоног төхөөрөмжийн жагсаалт

5.3. Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

5.3.1. Бүтэц, орон тоо

5.3.2. Ажиллагсдын мэргэжил, мэргэшлийн ур чадвар

5.3.3. Шинээр бий болгох ажлын байрны тоо

5.4. Зах зээлийн судалгаанд дараах мэдээллийг тусгана.

5.4.1. Зах зээлийн төлөв байдал

5.4.2. SWOT шинжилгээ

5.4.3. Хэрэглэгчдийн тодорхойлолт

5.5. Эдийн засгийн тооцоонд дараах мэдээллийг тусгана.

5.5.1. Үндсэн, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний нийт орлого

- 5.5.2. Борлуулалтын орлогын тооцоо
- 5.5.3. Үйлдвэрлэлийн зардлын тооцоо
- 5.5.4. Бүтээгдэхүүний өртгийн тооцоо
- 5.5.5. Бүтээгдэхүүний нэгжийн борлуулалтын
- 5.5.6. Үйлдвэр үйлчилгээ худалдааны үр ашгийн тооцоо
- 5.5.7. Төслийн өгөөж, өртгийн тооцоо
- 5.5.8. Төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгал
- 5.5.9. Зээлийн хөрөнгийн хүчин чадлын тооцоо
- 5.6. Дараах тохиолдолд зээлд хамрагдахгүй.

5.6.1. Нийт санхүүжилтийн 20-30%-аас доошгүй өөрийн эх үүсвэрийг бүрдүүлээгүй

5.6.2. Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлийн түүхтэй

5.6.3. Төслөөс авсан зээлийг төлсөн боловч зориулалтын бусаар ашигласан

5.6.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өртэй, хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн

5.6.5. Нийгмийн даатгал болон татварын байгууллагад өртэй байгаль орчин ба хүний эрүүл мэндэд хортой технологи, материал хэрэглэсэн, экологийн хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон.

Зургаа. Төсөл сонгон шалгаруулалт зарлах, хүлээн авах

6.1. Компани төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгсэл эсвэл олон нийтийн цахим хуудас, аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна. Төсөл хүлээн авах зарлалд төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.

6.2. Төслийг компани хүлээн авах бөгөөд хугацаа зарлагдахаас бусад үед хамаарахгүй.

Долоо. Төсөл сонгон шалгаруулах үе шат, ил тод байдал

7.1. Төсөл сонгон шалгаруулалт нь дараах үе шаттай байна.

7.1.1. Төслийн иж бүрдлийг шалгах

7.1.2. Төслийн иж бүрдлийг хангасан төсөлд төслийн судалгаа хийх

7.1.3. Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж сонгон шалгаруулах

Найм. Гэрээ байгуулах, хөрөнгө олгох

8.1. "Хөдөөгийн шийдэл" ОНӨХХК нь шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгжтэй зээлийн болон барьцааны гэрээг байгуулж, хөрөнгийг олгоно.

Ес. Бусад

9.1. Зээлээр олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

9.2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хагас, бүтэн жилд төсөл сонгон шалгаруулах болон хэрэгжилтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

ООо